



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/44/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Болормаа Утас: 51-261740 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГУЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ
ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖИЙГ
ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.ЧАНДМАН ТАНАА

2024.02.23 № 07/282

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх” төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх” төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны эцэст UBSWMP-2: Төвлөрсөн хогийн цэг болон барилгын хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт ашиглах 29 нэр төрлийн машин механизм, дагалдах хэрэгслүүдийг нийлүүлэх гэрээний дагуу Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Хот тохижилтын газарт 24 машин механизмыг хүлээлгэн өгсөн байна.

Үлдсэн 5 машин механизмыг гэрээний хугацаандаа нийлүүлээгүй тул гүйцэтгэгч байгууллагад 445,105.0 ам.долларын алданги тооцож, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03/46 дугаар албан бичгээр мэдэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Зээл, тусламжийн гэрээний дагуу 2018-2023 онд үйл ажиллагааны баталсан төлөвлөгөөний дагуу үндсэн 3 зорилтын хүрээнд 3 багц арга хэмжээг хэрэгжүүлж, тайлант оны эцэст төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 80.0 хувь, санхүүжилтийн зарцуулалт 34,186,912.5 мянган төгрөг буюу 68.2 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэгч байгууллага Нийслэлийн засаг даргын тамгын газраас 127,456.1 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авч, төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн менежер, захиргааны ажилтан, хог хаягдлын асуудал хариуцсан ажилтнуудын цалин, нийгмийн даатгал, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулж нийслэлийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлд нэгтгүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,141,632,764.54	34,293,024,327.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	226,233,921.89	106,111,896.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	226,233,921.89	106,111,896.65
3121	Төгрөг	293,135.24	1,463,332.51
31210	Төрийн сангийн харилцах	293,135.24	1,463,332.51
3122	Гадаад валют	225,940,786.65	104,648,564.14
31221	Төрийн сангийн харилцах	225,940,786.65	104,648,564.14
34	УРЬДЧИЛГАА	13,915,398,842.65	34,186,912,431.10
34600	Урьдчилж гарсан зардал	13,915,398,842.65	34,186,912,431.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14,141,632,764.54	34,293,024,327.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,000.00	1,483,331.44
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,000.00	1,483,331.44
41300	Өглөг	20,000.00	1,483,331.44
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	20,000.00	1,483,331.44
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42200	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,141,612,764.54	34,291,540,996.31
51	Засгийн газрын хувь оролцоо	14,141,612,764.54	34,291,540,996.31
512	Хуримтлагдсан үр дүн	14,141,612,764.54	34,291,540,996.31
51210	Өмнөх үеийн үр дүн	3,873,797,933.77	14,141,612,764.54
51220	Тайлант үеийн үр дүн	10,267,814,830.77	20,149,928,231.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	14,141,632,764.54	34,293,024,327.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	10,339,736,591.36	20,271,513,588.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГ	10,339,736,591.36	20,271,513,588.46
120	Нийтлэг татварын бус орлого	10,339,736,591.36	20,271,513,588.46
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,458,409,052.36	12,444,957,305.63
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	8,458,409,052.36	12,444,957,305.63
122	Тусламжийн орлого	1,881,327,539.00	7,826,556,282.83
122002	Хандив тусламж /гадаад/	1,881,327,539.00	7,826,556,282.83
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	125,903,571.40	121,805,998.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,903,571.40	121,805,998.18
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	125,903,571.40	121,805,998.18
210101	Үндсэн цалин	111,914,285.70	108,360,932.60
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	13,989,285.70	13,445,065.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	10,213,833,019.96	20,149,707,590.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	53,981,810.81	220,641.49
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	53,981,810.81	220,641.49
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
225004	Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдэх	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	10,267,814,830.77	20,149,928,231.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	240,122.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	240,122.00
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	240,122.00
1200	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	240,122.00
120009	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	240,122.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	135,723,328.67	120,582,788.73
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	135,723,328.67	120,582,788.73
210	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,723,328.67	120,582,788.73
210101	Үндсэн цалин	117,928,761.13	107,137,723.15
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,794,567.54	13,445,065.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(135,723,328.67)	(120,342,666.73)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	53,981,810.81	220,641.49
14	Бусад эх үүсвэрээр	53,981,810.81	220,641.49
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	53,981,810.81	220,641.49
6	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(81,741,517.86)	(120,122,025.24)
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	307,975,439.75	226,233,921.89
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,233,921.89	106,111,896.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	3,873,797,933.77	3,873,797,933.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		3,873,797,933.77	3,873,797,933.77
Тайлант үеийн үр дүн		10,267,814,830.77	10,267,814,830.77
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	14,141,612,764.54	14,141,612,764.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		14,141,612,764.54	14,141,612,764.54
Тайлант үеийн үр дүн		20,149,928,231.77	20,149,928,231.77
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	34,291,540,996.31	34,291,540,996.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,498,800,000.00	20,392,096,377.19	3,106,703,622.81	86.8
УРСГАЛ ЗАРДАЛ	153,800,000.00	120,582,788.73	33,217,211.27	78.4
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,800,000.00	120,582,788.73	33,217,211.27	78.4
Үндсэн цалин	133,800,000.00	107,137,723.15	26,662,276.85	80.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,725,000.00	13,445,065.58	3,279,934.42	80.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,275,000.00	-	3,275,000.00	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,275,000.00	-	3,275,000.00	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	10,900,000,000.00	7,826,556,282.83	3,073,443,717.17	71.8
Барилга байгууламж	10,900,000,000.00	7,826,556,282.83	3,073,443,717.17	71.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	12,445,000,000.00	12,444,957,305.63	42,694.37	100.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	12,445,000,000.00	12,444,957,305.63	42,694.37	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,498,800,000.00	20,271,753,710.46	3,227,046,289.54	86.3
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	240,122.00	(240,122.00)	0.0
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	240,122.00	(240,122.00)	0.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,598,800,000.00	12,444,957,305.63	153,842,694.37	98.8
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	12,598,800,000.00	12,444,957,305.63	153,842,694.37	98.8
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	10,900,000,000.00	7,826,556,282.83	3,073,443,717.17	71.8
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	10,900,000,000.00	7,826,556,282.83	3,073,443,717.17	71.8
Тохируулсан орлогын дүн		220,641.55		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		226,233,921.89		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		106,111,896.65		
Байгууллагын тоо	1	1		100.0
Ажиллагсдын тоо	5	5		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,371.8 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс төсвийг зориулалт бусаар зарцуулж Нийгмийн даатгалын байгууллагын албан тушаалтны буруутай үйлдэлд тогтоосон торгуулийг байгууллагаас төлсөн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажилтны буруугаас НДШ-ийн 6 дугаар сарын тайлан хоцроосон тул НД-ын байгууллагаас торгууль тавьсныг байгууллагын орон нутгийн төсвийн санхүүжилтээс зарцуулсан байна	1	1,371.8	1	1,371.8				
Дүн		1	1,371.8	1	1,371.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 167 мэдээллээс 146 мэдээлэл хугацаанд нь байршуулж үүнээс 12 мэдээг бүрэн мэдээлээгүй, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 19 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		